



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХОГЖЛИЙН
САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 08 сарын 01 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Үерийн усны аюулаас урьдчилан
сэргийлэх арга хэмжээ авах тухай

Улаанбаатар хотод төдийгүй нийт нутгаар олон жилийн дундажаас илүү бороо хур орж, гол, мөрөнгийн усны түвшин нэмэгдэж, тээврийн дэд бүтэц, тээвэрлэлтийн үйлчилгээнд хүндрэл, бэрхшээл учруулахуйц нөхцөл байдал үүсгэж байна.

Цаашид хур тунадас үргэлжлэн орох цаг агаарын урьдчилсан мэдээтэй байгаа тул үерийн усны аюулаас сэрэмжлүүлэх, үүсч болзошгүй аливаа осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, байгалийн гэнэтийн болзошгүй нөхцөл байдлын үед тээврийн аюулгүй байдлыг хангуулах, салбарын байгууллага, албан хаагчдын ажлын хариуцлага, бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч, хэрэгжүүлж ажиллахыг Салбарын нийт байгууллагын албан хаагч, аймаг, нийслэлийн Засаг дарга, авто замын өмчлөгч, эзэмшигч, хариуцагч аж ахуйн нэгж, байгууллага, төмөр замын суурь бүтэц, нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, ашиглагч, төмөр замын тээвэрлэлт, усан замын тээврийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагад Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг үндэслэн ДААЛГАХ НЬ:

Нэг. Авто зам, замын байгууламж, тээвэрлэлтийн аюулгүй байдлын чиглэлээр захиалагч, зөвлөх байгууллагад:

1.1 Авто зам, замын байгууламжуудын ашиглалтын найдвартай байдал, ашиглалтын шаардлагууд болон тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангуулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс үерийн ус давж урсах магадлалтай, үерийн улмаас эвдрэл гардаг хэсгүүдэд усны тооцоо судалгааг үе шаттай хийлгэж, нэмэлт ус зайлуулах байгууламж, хамгаалалтын далан барих төсөв хөрөнгийг шийдвэрлүүлэх болон бусад шаардлагатай арга хэмжээг авах;

1.2 Захиалагч, зөвлөх байгууллагын зүгээс авто замын ашиглалтын хэвийн байдлыг хангуулах, засвар, арчлалтын ажлыг тогтоосон хугацаанд хийж, болзошгүй үерлэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байгаа эсэхэд хяналт тавих.

Хариуцагч байгууллагад:

1.3 Авто замын арчлалт, урсгал засварыг хариуцагч аж ахуйн нэгж, байгууллагууд Авто замын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.5, 23.3.6 дахь заалтын дагуу гамшиг, ослын улмаас авто замд эвдрэл, гэмтэл гарч тээврийн хэрэгслийн хөдөлгөөн саатсан үед олон нийтэд мэдээлж, захиалагч болон зөвлөх байгууллагуудын хамт саадыг арилгах арга хэмжээг шуурхай авч ажиллах;

1.4 Байгалийн гамшиг, гэнэтийн осол, аюулын улмаас авто замд гарсан эвдрэл, гэмтлийг арилган тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлж, холбогдох төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах;

1.5 Авто зам, замын байгууламж, үерийн хамгаалалтын байгууламж, техник, хэрэгслийн ашиглалтын байдалд үзлэг шалгалтыг тогтмол хийж, ус зайлуулах байгууламжийг байнга бэлэн байлгах, гүүрийн тулгуур орчмын болон хоолойн орох гарах амсрын чулуун бэхэлгээний бүрэн бүтэн байдлыг хянах, сэргээн засварлах, цэвэрлэх, гольдирлыг хэвийн байдалд оруулах, замын шуудууг сэргээх, уулын гадаргуугийн ус залах, гуу жалга, ус нэвтрүүлэх суваг, шуудуу, хоолойн хог хаягдал цэвэрлэх ажлыг шуурхай зохион байгуулах зэрэг урьдчилан сэргийлэх засвар, арчлалтын ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх;

1.6 Байгалийн гэнэтийн үзэгдлийн улмаас авто зам, замын байгууламж эвдэрсэн тохиолдолд болон засвар, барилга угсралтын ажлын явцад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны норм дүрмийн хэрэгжилтийг хангуулан ажиллах, "Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм" MNS 4596:2014 стандартын дагуу анхааруулах, мэдээлэх тэмдэг, тэмдэглэл, хашилтыг байршуулан осол аваараас урьдчилан сэргийлэх;

1.7 Голын усны түвшин нэмэгдэж, үерийн байдалд шилжсэн үед голын усны горимд байнгын хэмжилт, ажиглалтыг тогтмол хийж, завсрын тулгуур, алгасал байгууламж болон бусад бүтээцүүдийн аюулгүй байдлын шаардлагыг хангуулах, гармаар зорчихгүй зориулалтын гарцтай газраар зорчих, батлагдсан замын маршрутаар зорчуулах, усны үер болох магадлалтай газраар нэвтрүүлэхгүй байх, даацын зөвшөөрөгдсөн гүүр, замын байгууламжаар зорчуулах арга хэмжээг авах ажлыг зохион байгуулах;

1.8 Олон улс, улсын болон орон нутгийн чанартай авто замд байрлаж буй төмөрбетон, модон гүүрүүдийн үзлэг судалгааг тогтмол хийж, гүүрийн паспортыг тогтмол хөтлөж, эвдрэл гэмтлийн талаар тэмдэглэж, захиалагч, зөвлөх болон бусад холбогдох байгууллагуудад тухай бүр хандаж, шуурхай арга хэмжээг авч байх.

Барилга угсралтын ажлын гүйцэтгэгч байгууллагад:

1.9 Авто зам, замын байгууламжийн гүйцэтгэгч байгууллагууд гүүр, ус зайлуулах байгууламжийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэхдээ технологийн болон нийтийн тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх түр зам, гүүрийг барих, голын гольдрилыг өөрчлөх төлөвлөгөө, аргачлалыг боловсруулж, захиалагч, зөвлөх байгууллагаар баталгаажуулж, иргэдийн аюулгүй байдал, хэвийн зорчих нөхцөлийг хангуулан ажиллах.

Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

1.10 Байгалийн гамшиг, гэнэтийн осол, аюулын улмаас үүссэн авто замын эвдрэл, гэмтлийг шуурхай засварлах шаардлага гарсан үед Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7 дахь заалтын дагуу харьяа нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс тээвэр, холбооны хэрэгсэл, машин механизм, эд хөрөнгийг нөхөн олговортойгоор дайчлан гаргуулах, хүн хүчний туслалцаа авах ажлыг зохион байгуулж, авто замын асуудал хариуцсан болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах;

1.11 Үерийн хамгаалалтын далан суваг, авто замын борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээ, өргөлтийн насос станц, газар доорх усны мониторингийн цооног, түүний барилга байгууламжийн засвар ашиглалт, цэвэрлэгээ үйлчилгээг хариуцах байгууллагыг тодорхой болгох, түүнд тавих хяналтыг сайжруулж, заавар зөвлөмж өгөх, эвдрэл гэмтлийн үед шуурхай арга хэмжээ авч, шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангуулах;

1.12 Суурин газарт үерийн аюулд өртөж болзошгүй аюултай бүс болох үерийн усны зам, голын гольдрил, гуу, жалга, хуурай сайр, ус хальдаг эрэг, усны барилга байгууламжийн далан сувгийн хамгаалалтын бүсэд зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй суурьшсан айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын барилга байгууламжийн судалгааг гаргаж, эрсдэлтэй бүсээс нүүлгэн шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу үе шаттай зохион байгуулах;

1.13 Орон нутгийн чанартай авто замд үзлэг шалгалтыг норм дүрмийн дагуу хийж, авто замын зурвас газар, гүүр, хоолойн хэсэгт байгаа хог хаягдал, малын сэг зэм, хатуу болон зөөлөн материалын хаягдлыг цэвэрлэх, гол горхины урсгал гольдрилыг чиглүүлэн засах, урсгал залах далан, шуудууг сэргээн засварлах, хөрс угаагдалтанд орох эрсдэлтэй бүсэд хамгаалах арга хэмжээг авч, үерийн ус урсан өнгөрсний дараа ус зайлуулах шуудуу, хиймэл байгууламжид тогтсон хог хаягдлыг дахин цэвэрлэхэд хяналт тавьж ажиллах;

1.14 Байгалийн гамшиг, гэнэтийн осол, аюулын улмаас үүссэн нөхцөл байдлын үед нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлт, ачаа тээвэр, усан замын тээврийн үйлчилгээг зохицуулах, шаардлагатай газруудад тээвэрлэлтийг түр хориглох, хязгаарлах талаар зохих шийдвэрийг гаргаж, мөрдүүлэх;

1.15 Улс, хот хооронд, орон нутаг, хотын доторх нийтийн тээвэр, ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ, тээврийн хэрэгсэл бүхий иргэдийн зорчих хөдөлгөөнийг батлагдсан маршрут, баталгаатай авто замаар гүйцэтгүүлэхэд хяналт, шалгалтын үйл ажиллагаагаа чиглүүлж, тээвэрлэлтийн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг сахиулах;

1.16 Гол, мөрөн, нуур бүхий аймаг, нийслэлд эрэг дагуу зориулалтын бус хийлдэг хөвөгч хэрэгслүүд ашиглахаас татгалзах, зөвлөмж, сэрэмжлүүлгийг өгч ажиллах;

1.17 Усан замын тээврийн үйлчилгээний аялах чиглэл, хөвөх бүс, цагийн хуваарийг тогтоож түүнийг мөрдүүлэн, хяналт тавьж ажиллаж.

“Авто тээврийн Үндэсний төв” ТӨҮГ-д:

1.18 Иргэд, тээврийн хэрэгслийн жолооч нарт үерийн усны улмаас эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн, ашиглалтын шаардлага хангаагүй, эвдрэлтэй гүүр, замын байгууламжийн талаарх мэдээллийг шуурхай хүргэж, Зам, тээврийн хөгжлийн яам, Зам, тээврийн хөгжлийн төв, Онцгой байдлын ерөнхий газар болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран зохих арга хэмжээг тухай бүр авахуулж байх, урьдчилан сэргийлэх зөвлөмж, сэрэмжлүүлэг өгч, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах.

Далайн захиргаанд:

1.19. Усан замын тээврийн ажил үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд усан замын тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж, тогтоосон аяллын чиглэл, цагийн хуваарийн дагуу хөвөлтөд гарахад мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж, сэрэмжлүүлэг өгч, тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагааг зогсоох, хяналт тавих.

Хоёр. Төмөр замын тээврийн аюулгүй байдлын чиглэлээр:

Төмөр замын суурь бүтэц эзэмшигч, ашиглагч, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагад:

2.1 Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй үерийн усны аюулаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн дотоод хяналтын төлөвлөгөөт болон гэнэтийн эргүүл шалгалтыг бүх шатанд тогтмол хийх, илэрсэн зөрчил, дутагдлыг шуурхай арилгуулан баталгаажуулж байх;

2.2 Сүйрэл, осол, гологдлоос урьдчилан сэргийлэх, сүйрэл, осол гаргахгүй байх, гологдолгүй ажиллахад бүх талын арга хэмжээ авах, сэргээн босголт, засварын ажлын үед ашиглах машин механизм, техник хэрэгсэл, хүн хүчний бэлэн байдлыг хангаж ажиллах;

2.3 Төмөр замын тээврийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэвийн нөхцөлийг хангах, осол гологдолоос урьдчилан сэргийлэхэд онцгой анхаарч, үерийн уснаас урьдчилан сэргийлэх ажлын зориулалттай материалын нөөцийг нэмэгдүүлэх, байршуулах арга

хэмжээ авах, шаардагдах зардал, хөрөнгийг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж, зориулалтын дагуу зарцуулах;

2.4 Үерийн усны олон удаагийн давтамжаар зам, замын байгууламж угаагдаж ихээхэн хэмжээний хохирол учруулж буй эрсдэлтэй цэгүүдэд шалтгаан нөхцөлийг нь тодорхойлох, арилгах чиглэлээр тодорхой үр дүнтэй ажил зохион байгуулах, ялангуяа Багахангай-Бор-Өндөр-Замын-Үүд чиглэлийн төмөр зам дагууд мэргэжлийн гидротехникийн байгууллагаар ус зүйн тооцоо, судалгаа хийлгэж, гаргасан судалгаанд үндэслэн үерийн уснаас хамгаалах барилга, байгууламжийн зураг төслийг боловсруулж, цаашдын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах;

2.5 Үерийн усанд угаагдсан зам, замын байгууламжийг сэргээн засварлах, хэвийн ажиллагаанд оруулах чиглэлээр шаардагдах төсөв хөрөнгөний асуудлыг шийдвэрлэх, яаралтай засварлах арга хэмжээ авч, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах;

2.6 Төмөр замын суурь бүтцийн үзлэг, арчлалтын чанарыг сайжруулах, ашиглалтын хугацаа хэтэрсэн болон дуусаж буй зам, замын байгууламжид туршилт, оношилгоо тогтмол хийлгэх, их засвар, шинэчлэлтийн ажлыг норм дүрэм, стандартын дагуу төлөвлөгөөт хугацаанд хийж гүйцэтгэх.

Гурав. Үерийн усны болон байгалийн гамшиг, аюул, ослын талаарх анхны мэдээллийг Зам тээврийн хөгжлийн яамны удирдлага, холбогдох албан тушаалтан, байгууллагад нэн даруй мэдээлж, хор уршгийг арилгах арга хэмжээг шуурхай авч, биечлэн зохион байгуулж ажиллах, албан даалгаврыг хэрэгжүүлж, ажлын явц, үр дүнг сар бүр тайлагнаж ажиллахыг харьяа байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

Дөрөв. Энэхүү албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг сар тутам танилцуулж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар/А.Мөнхбат/-д даалгасугай.

